



# БАНКНЫ САЛБАРЫН ТОЙМ


2021 оны III улирлын тайлан

ЗӨӨЛӨН    ГАЗАРДАЖ    ЧАДАХ УУ?

Банкны салбарын үзүүлэлт харьцангуй тогтвортой, өсөлттэй байна. Гэвч санхүүгийн зах зээлд тодорхой бус байдал, эрсдэл хуримтлагдсаар. Сүүлийн хоёр жил гаруйн хугацаанд үлэмж хэмжээний мөнгөний, сангийн тэлэх бодлогыг хэрэгжүүлсэн. Улмаар ААН-үүдэд хөнгөлөлттэй зээл олгож эхэлсэн. Харин эдгээр ААН-үүд 2022 оны сүүлээс зээлээ эргэн төлж эхлэх бөгөөд зээлийн чанарт ихээхэн сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй байна.

Монгол Улсын айл, өрхүүдийн 50 хувь нь зээлтэй. 2022 он гараад өрхүүдийн орлого нэмэгдээгүй үед тэд хөнгөлөлттэй байсан төлбөрүүд, ипотекийн зээл зэргийг төлж эхэлнэ. Худалдан авах чадвар огцом буурсан энэ нөхцөлд өрхүүдийн зээл муудах магадлал нэлээд өндөр болно.

Түүнчлэн зээлийн график өөрчилсөн, зээлийн чанарын ангилалд өөрчлөлт оруулсан нөлөө нь ирэх онд гарна. Тиймээс 2022 он банкны системд нэлээд сорилттой жил болох талтай. Гагцхүү зөөлөн газардаж чадах эсэх нь бодлогын тохиргоо хэрхэн хийгдэх, эдийн засгийн нөхцөл байдал яаж өөрчлөгдөхөөс хамаарна.



## ЗӨӨЛӨН ГАЗАРДАЖ ЧАДАХ УУ?


## 2021 оны 3-р улиралд иргэдэд олгосон зээл нэмэгдэв.

Иргэдэд олгож буй цалин тэтгэвэр болон хадгаламж барьцаалсан зээл нэмэгдэв.

Нэг талдаа зээлийн эрэлт бага байгаа бол нөгөө талдаа эрсдэлтэй нөхцөлд банкуудын зээл гаргах сонирхол бага байна

**Онцлох өөрчлөлт,  
энгийн тайлбар**

Иргэдийн зээл олголт, жил бүрийн 3-р улирлаар харуулав.



**Онолын  
тодорхойлолт**

**2021 оны 3-р  
улирлын  
гүйцэтгэл**

Тэрбум ₮

**Банкны шинээр олгосон  
зээл**

Жич: Тухайн жилд банкны шинээр гаргасан зээлийн хэмжээгээр зээлийн үлдэгдэл нэмэгддэг.

Шинээр иргэдэд олгосон  
зээлийн хэмжээ өсөв.

**30%**

# 2021 ОНЫ 3-Р УЛИРЛЫН БАНКНЫ САЛБАРЫН ОНЦЛОХ ӨӨРЧЛӨЛТ, ЦААШДЫН ХАНДЛАГА

---



Эдийн засгийг дэмжих 10 их наядын хөтөлбөрийн хүрээнд 3 хувийн хүүтэй зээл болон 9 хувийн репо санхүүжилтийн нөлөөгөөр нийт зээл 17 хувиар өсөв.



Уул уурхай, ХАА болон Барилгын салбарын 5 зээл тутмын 1 нь чанаргүйтэж байгаа бол боловсруулах салбарын 4 зээл тутмын 1 нь чанаргүйтэж байна.



Тээвэр ложистикийн хэвийн биш үйл ажиллагаанаас үүдэлтэй хэрэглээ хязгаарлагдаж, хөрөнгө оруулалтын боломж дутмаг байгаагаас хадгаламж нэмэгджээ.



Системийн нөлөө бүхий 5 банкны санхүүгийн үзүүлэлт харьцангуй сайн байна. Зээл өсөлттэй, зээлийн чанаргүйдэл буурах хандлагатай, эх үүсвэр болон өөрийн хөрөнгө өсөлттэй байна.



2022 он гарсаар хөнгөлөлттэй зээл авсан ААН-үүдийн зээлийн эргэн төлөлт эхэлнэ. Энэ нь бизнесийн зээлийн чанарт сөргөөр нөлөөлж болзошгүй байна. Түүнчлэн иргэдийн зээл он гараад муудах дүр зурагтай байна.



Ирэх 1 жилийн хугацаанд системийн нөлөө бүхий банкууд IPO хийхээр байгаа зэрэг нь цар тахлын энэ үед томоохон сорилт байхаар байна.

# БАНКУУДЫН САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТ

---

2021 оны III улирлын гүйцэтгэл

---

## Банкны зээлийн багц

Жич: Зээлийн үлдэгдэл нь шинээр олгосон зээлээр нэмэгдэж, эргэн төлөлтөөр буурч байдаг.


# +17%

Зээлийн үлдэгдэл дунджаар 17 хувиар өсөв.

Эх сурвалж: Монголбанк  
Үндэсний Статистикийн Хороо

## Ажлын байрыг дэмжих зээлийг 2021 онд олгож эхэлснээр зээл сэргэлээ.

Ипотекийн зээл болон 10 их наяд төгрөгийн эдийн засгийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд олгогдож буй репо санхүүжилт, 3 хувийн хөнгөлөлттэй ажлын байрыг дэмжих зээлийн хөтөлбөр нь банкны зээлийн өсөлтийг бий болгов




## 2021 оны 3-р улиралд иргэдэд олгосон зээл нэмэгдэв.

Иргэдэд олгож буй цалин тэтгэвэр болон хадгаламж барьцаалсан зээл нэмэгдэв.

Нэг талдаа зээлийн эрэлт бага байгаа бол нөгөө талдаа эрсдэлтэй нөхцөлд банкуудын зээл гаргах сонирхол бага байна

Иргэдийн зээл олголт, жил бүрийн 3-р улирлаар харуулав.



## Банкны шинээр олгосон зээл

Жич: Тухайн жилд банкны шинээр гаргасан зээлийн хэмжээгээр зээлийн үлдэгдэл нэмэгддэг.


Шинээр иргэдэд олгосон зээлийн хэмжээ өсөв.

# 30%

## 2021 оны 3-р улиралд эдийн засгийн голлох салбаруудын зээл олголт нэмэгджээ.

Эдийн засгийг дэмжих 10 их наяд төгрөгийн хөтөлбөрийн зээлийг банкууд өөрийн санхүүжилтээр олгож буй нь эдийн засгийг дэмжих хөшүүрэг болж байна.

Бизнесийн зээл олголт, жил бүрийн 3-р улирлаар харуулав.



## Банкны шинээр олгосон ЗЭЭЛ

Жич: Тухайн жилд банкны шинээр гаргасан зээлийн хэмжээгээр зээлийн үлдэгдэл нэмэгддэг.

Бизнесийн зээлийн  
ХЭМЖЭЭ ӨСӨВ.

# 70%




## Хэрэглээний зээлийн багцын чанар аажмаар муудаж байна.

Төрөөс өрхүүдэд өгч буй тэтгэмж аажмаар буурч хэвийн түвшинд хүрнэ. Иймээс өрхийн орлого нэмэгдэхгүй бол зээлийн чанар муудах эрсдэлтэй.

Хөтөлбөрийн хүрээнд олгосон бизнесийн зээлийн эргэн төлөлт ирэх оноос хийгдэж эхлэхэд ААН-үүдэд зээлийн төлбөрийн дарамт нэмэгдэхээр байна.

Иргэдийн чанаргүй зээлийн харьцаа, жил бүрийн 3-р улирлаар харуулав.



Бизнесийн чанаргүй зээлийн харьцаа, жил бүрийн 3-р улирлаар харуулав



## Банкны зээлийн чанар

Жич: 90 хоногоос дээш хугацаагаар зээлээ төлөөгүй нөхцөлд чанаргүй зээлд шилждэг.

2021 оны 3-р улирлын байдлаар 10 зээл тутмын 1 нь чанаргүйтсэн байна.


# 10.3%

## Хэрэглээний хязгаарлалт, хөрөнгө оруулалтын боломж дутмаг байдал нь хадгаламжийг нэмэгдүүлжээ.

Цар тахлын нөхцөл байдлаас үүдэлтэй олон хоногийн хөл хорио, тээвэр ложистикийн хэвийн биш үйл ажиллагаанаас үүдэж хэрэглээний хязгаарлалт нэмэгдсэн бол хөрөнгө оруулалтын боломж дутмаг байгаагаас хадгаламж нэмэгдсэн.

Харилцах, хадгаламжийн дүн, 2021 оны 3-р дугаар улирлын байдлаар

Их наяд ₮



## Банкны эх үүсвэр


Жич: Энэ нь банкны татан төвлөрүүлсэн харилцах, хадгаламжийг хэлдэг.

Төгрөгийн хадгаламж өсөв.

# +31%

# Хөнгөлөлттэй зээлийн улмаас буураад байсан зээлийн хүү аажмаар өсөж эхлэв.

2021 оны эхний хагас жилд хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийг оруулаад зээлийн хүү 11.5 хувь хүрээд байсан бол 3 дугаар улирлын байдлаар 1.8 нэгжээр өсөж 13.7 хувьд хүрчээ.



## Банкны жигнэсэн дундаж хүү

Жич: Банкуудын шинээр татсан эх үүсвэрийн хүү, олгосон зээлийн хүү нь цаг хугацаа, мөнгөн дүнгийн хувьд жинлэгдсэн дундаж хүүг хэлнэ.

Шинээр татсан хадгаламжийн жигнэсэн дундаж хүү буурсан байна.

# 7%

# БАНКУУДЫН САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТ

---

2021 оны III улирлын гүйцэтгэл

---

## Банкны актив буюу хөрөнгө

Жич: Банкны нийт өр төлбөр дээр эздийн өмчийг нэмээд бүхэлд нь банкны хөрөнгө буюу актив гэнэ.

Системийн нөлөө бүхий  
банкуудын актив өсөв.


# 13%

Эх сурвалж: Монголбанк  
Үндэсний Статистикийн Хороо

## Банкны системийн нийт актив 4.3 их наяд төгрөгөөр өссөнөөс системийн нөлөө бүхий банкуудын актив 4 их наяд төгрөгөөр нэмэгджээ.

Хаан банкны актив 2 их наяд төгрөгөөр нэмэгдсэн бол ХХБанкны актив 1.3 их наяд төгрөгөөр нэмэгджээ.

Банкны нийт актив, 2021 оны 3-р улирлын байдлаар (их наяд төгрөг)




Эх сурвалж: Банкуудын аудитлагдаагүй тайлан

# Хөнгөлөлттэй зээлийн нөлөөгөөр банкуудын зээлийн багц 2.8 их наяд төгрөгөөр өсөв.

2020 онд цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан банкуудын зээлийн багц бууралттай байсан бол 2021 оны 3 дугаар улиралд багцууд өссөн байна.

Банкны нийт зээлийн үлдэгдэл, 2021 оны 3-р дугаар улирлын байдлаар



## Банкны нийт зээлийн үлдэгдэл

Жич: Иргэд, аж ахуй нэгжид олгосон зээлийн үлдэгдлийн хэмжээ.

Системийн нөлөө бүхий банкуудын зээлийн багц өсөв.

# 27%

Эх сурвалж: Банкуудын аудитлагдаагүй тайла

## Банкны эх үүсвэр

Жич: Иргэд, байгууллага болон хөрөнгө оруулагчдаас татсан өр төлбөрийн хэмжээ.

Банкуудын эх үүсвэр  
нэмэгдэв.


# 15%

Эх сурвалж: Монголбанк  
Үндэсний Статистикийн Хороо

## 2021 оны 3 дугаар улирлын байдлаар банкны салбарын нийт эх үүсвэр 4.1 их наяд төгрөгөөр нэмэгджээ

Хаан банкны эх үүсвэр 1.9 их наяд төгрөгөөр өссөн байна.

Банкны нийт эх үүсвэр, 2021 оны 3 дугаар улирлын байдлаар харуулав




Эх сурвалж: Банкуудын аудитлагдаагүй тайлан

# Багцын тэлэлтээс үүдэлтэйгээр чанаргүй зээлийн харьцаа буурчээ.

3 хувийн хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрт шилжиж зээлийн төлбөр буурсан, зарим байгууллагуудын бизнесийн зээлийн нөхцөлд өөрчлөлт оруулсан зэрэг нь чанаргүй зээлийн харьцааг буурахад нөлөөлжээ.

Банкны чанаргүй зээлийн харьцаа, 2021 оны 3-р улирлын байдлаар харуулав.



Эх сурвалж: Банкуудын аудитлагдаагүй тайлан

## Банкны зээлийн чанар

Жич: 90 хоногоос дээш хугацаагаар зээлээ төлөөгүй нөхцөлд чанаргүй зээлд шилждэг.

Системийн нөлөө бүхий  
банкуудын чанаргүй  
зээлийн харьцаа буурав.

# 8%



## Өөрийн хөрөнгийн хүрэлцээ

Жич: Санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлээс гарах алдагдлыг хаахад хүрэлцэхүйц хэмжээний өөрийн хөрөнгөтэй эсэхийг тодорхойлсон үнэлгээг хэлдэг

Банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээний дундаж


# 15%

Эх сурвалж: Монголбанк  
Үндэсний Статистикийн Хороо

## Банкууд өөрийн хөрөнгийн хүрэлцээний шаардлагыг хангаж байна.

Эдийн засгийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд банкууд ЖДҮ-дэд зээл олгож буй нь өөрийн хөрөнгийн хүрэлцээг бууруулахад нөлөөлөв.

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ, 2021 оны 3-р улирлын байдлаар




2019Q3	2020Q3	2021Q3	2019Q3	2020Q3	2021Q3	2019Q3	2020Q3	2021Q3	2019Q3	2020Q3	2021Q3	2019Q3	2020Q3	2021Q3
Хаан			ХХБ			Голомт			Төрийн банк			Хас		

Эх сурвалж: Банкуудын тайлан

# Системийн нөлөө бүхий 5 банк нь хөрвөх чадварын харьцаа үзүүлэлтийг хангаж байна.

Цар тахал гарсантай холбоотой хөтөлбөрийн зээлээс бусад зээлийн олголт өсөөгүй байна. Улмаар банкуудын хөрвөх чадварын харьцаа үзүүлэлт өндөр хэвээр байна.

Хөрвөх чадварын харьцаа, 2021 оны 3 улирлын байдлаар



Хөрвөх чадварын харьцаа  
Жич: Богино хугацаат төлбөрүүдийг цаг тухайд нь төлөх чадварыг хэмждэг харьцаа.

Системийн нөлөө бүхий  
банкуудын хөрвөх чадварын  
харьцаа үзүүлэлтийн дундаж

# 41%


# ЦАР ТАХЛЫН ҮЕ ДЭХ МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН

**2021 оны III улирал:** Эдийн засгийн өсөлт 3.6 хувьтай гарлаа. Эдийн засаг өсөлттэй байгаа хэдий ч 1, 2 –р улиралтай харьцуулахад өсөлтийн хурд саарсан байна. Эдийн засгийн цусны эргэлт болох хөрөнгө оруулалт талаасаа банкны зээлийн өсөлт нь эдийн засгийг дэмжиж байна. Цар тахлын нөхцөл байдалтай холбоотой экспорт, импорт дээр гацаа үүсэж байгаа нь үнийн өсөлтийг бий болгож байна. 10 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд инфляц 9.3 хувьтай байгаа нь 2020 оноос хойш тасралтгүй өссөн үзүүлэлт юм.

**Төлөв байдал:** 2022 онд эдийн засаг 4-5 орчим хувьд өсөхөөр байна. Өсөлтийг сааруулж байгаа хүчин зүйлс нь дотоодын цар тахлын нөхцөл байдал, гадаад худалдаа дээр үүссэн гацаа зэргийг дурдаж болохоор байна. Энэ хэвээрээ импортын гацаа үргэлжлэх нь өргөн хэрэглээний барааны нийлүүлэлтийг бууруулж, улмаар үнийн өсөлт цаашид эрчимжих эрсдэлтэй байна. 2 жил гаруй хугацаанд цар тахлын хүнд нөхцөлд бодит сектор нэлээд хүндэрсэн. Тус нөлөө нь ирэх жилүүдэд санхүүгийн секторт хүчтэй нөлөөлөх магадлалтай байна. Тиймээс эдийн засагт үүсээд буй хүндрэлүүдийг бодлогын түвшинд шийдэх, тохируулга хийх нь үүсэж болзошгүй эрсдэлийг бууруулах ач холбогдолтой байна.

## 2021 оны 3-р улиралд эдийн засаг 3.6 хувиар өсөв.


2021 оны эхний улиралд уул уурхайн салбарын нөлөөгөөр эдийн засаг эрчимтэй сэргэсэн ч цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан экспорт гацсан нь 2, 3 дугаар улиралд уул уурхайн салбарын өсөлт саарахад хүчтэй нөлөөллөө.




# Тээвэрлэлт хүндрэлтэй байгаа ч үнийн өсөлтөөс шалтгаалж худалдааны эргэлт багасаагүй байна.

- Экспортын биет хэмжээ өсөлтгүй байгаа ч түүхий эдийн үнийн өсөлтөөс шалтгаалан зэсийн баяжмалын орлого **18 хувиар** өсжээ.
- Импортын бодит хэмжээ өсөлтгүй байгаа ч дэлхийн зах зээл дээрх үнийн өсөлтөөс хамаарч нефть, хүнсний бүтээгдэхүүний импортын дүн нэмэгджээ.

Экспортын хэмжээ, бүтээгдэхүүний төрлөөр




Импортын хэмжээ, бүтээгдэхүүний төрлөөр



# Төгрөгийн нэрлэсэн ханш тогтвортой байсан ч төлбөрийн тэнцэл алдагдалтай байлаа.

- Төлбөрийн тэнцлийн алдагдал нэмэгдэж, төгрөгийн бодит ханш чангарсан нь ирээдүйд төгрөгийн нэрлэсэн ханш сулрах хүлээлтийг бий болгож байна.
- Гадаад худалдааны тэнцэл 3 дугаар улиралд эерэг байгаа хэдий ч төлбөрийн тэнцэл **526 сая долларын** алдагдалтай гарав.



# Инфляци өсөж хадгаламжийн бодит хүү сөрөг болов.


- Хүнс, хатуу, түлшний үнэ тогтмол өсөж, цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан тээвэр, ложистик хэвийн ажиллахгүй байгаагаас үүдэн инфляци өндөр байна. Цаашид тээвэр, ложистик хэвийн түвшинд ажиллахгүй бол инфляцийн түвшин нэмэгдсээр байх хандлагатай байна.
- Бодлогын хүү өөрчлөгдсөнгүй.
- Нийлүүлэлтээс үүдэлтэй инфляцийн нөлөөгөөр хугацаатай хадгаламжийн бодит хүү -2 хувьд хүрэв.




# 2021 оны эхний 9 сарын байдлаар төсвийн үндсэн тэнцэл 698 тэрбум төгрөгийн алдагдалтай байна.

Ковид-19 цар тахлын эдийн засагт үзүүлэх нөлөөллийг багасгах, хүн амын эрүүл мэндийг хамгаалахын тулд ЗГ-аас авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээнээс хамаарч төсвийн үндсэн тэнцэл сүүлийн 3 жил алдагдалтай гарчээ. Цаашид ч цар тахлын нөхцөл байдал сайжрахгүй бол төсвийн үндсэн тэнцлийн алдагдал урт хугацаанд үргэлжлэх төлөвтэй байна.


### Төсвийн орлогын ДНБ-д эзлэх хувь



### Төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь



### Үндсэн тэнцэл



2022\* төсвийн төсөөлөл

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо